

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/79/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](#)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Аудитор: Б.Одгэрэл  
Утас: 86032989, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч



УВС АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН  
ГАЗРЫН ДАРГА Т.ТӨРТОГТОХ  
ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.18 № УРА-2023/79/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Гаалийн шинэчлэл"-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 27.2 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр "Боршоо" боомтыг олон улсын жишигт нийцүүлэн өргөтгөн шинэчлэх төслийн бүтээн байгуулалтын ажил 2020 оноос хэрэгжиж, 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр улсын комисс ажиллаж барилга, байгууламжуудаас дулаан агуулах, лабораторийн байр, албан хаагчдын амьдрах орон сууцны байрыг хэсэгчлэн хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас

0200200556

аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Лөгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>41,611,494.00</b>	<b>81,904,731.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>139,079.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0.00</b>	<b>139,079.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	0.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	139,079.00
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,444,827,528.22</b>	<b>2,683,051,579.74</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,290,171,503.50</b>	<b>2,539,141,938.30</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	779,240,148.81	786,791,248.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	-128,563,992.04	-164,846,687.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,400,000.00	257,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-141,391,666.71	-168,175,000.11
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,117,861,493.82	2,981,621,928.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-598,365,678.44	-1,158,393,033.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,341,133.00	54,206,121.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,349,934.94	-49,462,638.44
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>154,656,024.72</b>	<b>143,909,641.44</b>
39301	Програм хангамж	43,635,533.00	54,758,159.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-11,499,508.28	-33,368,517.56
39303	Бусад биет бус хөрөнгө	122,520,000.00	122,520,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,486,439,022.22</b>	<b>2,764,956,310.74</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>41100</b>	<b>Богино хугацаат үнэт цаас</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,486,439,022.22</b>	<b>2,764,956,310.74</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,486,439,022.22</b>	<b>2,764,956,310.74</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,836,065,647.36	1,836,065,647.36
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,836,065,647.36	1,836,065,647.36
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-549,668,427.40</b>	<b>728,848,861.12</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-317,966,147.83	-549,668,427.40
51220	Тайлант үеийн үр дүн	-231,702,279.57	1,278,517,288.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	200,041,802.26	200,041,802.26
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,486,439,022.22</b>	<b>2,764,956,310.74</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>856,437,750.00</b>	<b>2,721,694,153.39</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,525,050.00</b>	<b>1,468,662,453.39</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>7,525,050.00</b>	<b>1,468,662,453.39</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,652,700.00</b>	<b>1,468,662,453.39</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	70,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,582,700.00	1,468,592,453.39
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,872,350.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>848,912,700.00</b>	<b>1,253,031,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>842,616,700.00</b>	<b>1,253,031,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	842,616,700.00	1,253,031,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,296,000.00</b>	<b>0.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,296,000.00	0.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,073,380,191.47</b>	<b>1,443,176,864.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,073,380,191.47</b>	<b>1,443,176,864.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,048,715,065.29</b>	<b>1,408,659,209.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>627,801,894.96</b>	<b>875,014,598.20</b>
210101	Үндсэн цалин	588,947,394.96	793,621,598.20
210102	Нэмэгдэл	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,854,500.00	81,393,000.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>86,075,788.01</b>	<b>110,866,105.20</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,971,329.97	77,138,197.98
210202	Тэтгэмжийн даатгал	4,202,865.97	4,662,777.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,937,152.57	4,086,275.61
210204	Ажилгүйдлийн даатгал	6,215,830.31	8,633,752.27
210205	Эрүүл мэндийн даатгал	11,748,609.19	16,345,101.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,645,205.85</b>	<b>42,761,076.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,091,132.85	19,794,515.00
210302	Түлш, халаалт	9,301,363.00	22,470,781.00
210303	Цэвэр, бохир ус	252,710.00	495,780.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,829,191.00</b>	<b>50,933,260.00</b>
210401	Бичиг хэрэг	3,293,330.00	3,367,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,856,582.00	32,473,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,410,379.00	2,353,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,000.00	229,360.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,033,900.00	12,509,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>3,914,760.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	3,914,760.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,946,250.00</b>	<b>51,794,670.75</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,045,750.00	21,154,920.75
210604	Урсгал засвар	8,900,500.00	30,639,750.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>4,790,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	4,790,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,329,478.00</b>	<b>12,499,918.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	632,407.00	4,165,180.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,257,637.00	2,453,637.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	333,279.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	50,000.00
210807	Газрын төлбөр	1,919,600.00	1,781,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	267,834.00	2,886,622.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>253,087,257.47</b>	<b>256,084,721.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	251,077,257.47	256,084,721.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,665,126.18</b>	<b>34,517,655.60</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>1,800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>24,665,126.18</b>	<b>32,717,655.60</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,369,126.18	32,717,655.60
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,296,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-216,942,441.47</b>	<b>1,278,517,288.52</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,759,838.10</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	14,736,793.10	0.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	23,045.00	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-231,702,279.57</b>	<b>1,278,517,288.52</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>848,982,700.00</b>	<b>1,253,101,700.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>70,000.00</b>	<b>70,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>70,000.00</b>	<b>70,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>70,000.00</b>	<b>70,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	70,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>848,912,700.00</b>	<b>1,253,031,700.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>842,616,700.00</b>	<b>1,253,031,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	842,616,700.00	1,253,031,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>6,296,000.00</b>	<b>0.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,296,000.00	0.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>820,743,250.00</b>	<b>1,216,285,700.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>820,743,250.00</b>	<b>1,216,285,700.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>796,078,123.82</b>	<b>1,181,768,044.40</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>627,801,943.33</b>	<b>875,122,587.96</b>
210101	Үндсэн цалин	371,743,414.29	519,787,932.06
210102	Нэмэгдэл	173,738,096.94	215,284,333.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,084,929.00	73,450,124.00
210104	Урамшуулал	44,235,503.10	66,600,198.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>86,075,739.64</b>	<b>110,897,194.44</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,971,329.97	76,894,989.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,804,523.88	9,002,144.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,401,145.32	6,736,507.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,081,703.84	1,835,903.51
210205	Эрүүл мэндийн даатгал	10,817,036.63	16,427,649.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,645,205.85</b>	<b>42,761,076.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,091,132.85	19,794,515.00
210302	Түлш, халаалт	9,301,363.00	22,470,781.00
210303	Цэвэр, бохир ус	252,710.00	495,780.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,635,591.00</b>	<b>86,175,560.00</b>
210401	Бичиг хэрэг	3,413,730.00	3,241,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,981,582.00	32,473,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,410,379.00	2,353,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,000.00	73,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,594,900.00	48,034,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>8,241,750.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	8,241,750.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22,501,500.00</b>	<b>44,166,480.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	504,430.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,191,000.00	12,617,400.00
210604	Урсгал засвар	9,310,500.00	31,044,650.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>4,790,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	4,790,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,208,144.00</b>	<b>9,613,296.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	632,407.00	4,165,180.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,257,637.00	2,453,637.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	333,279.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	50,000.00
210807	Газрын төлбөр	1,919,600.00	1,781,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	146,500.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>210,000.00</b>	<b>0.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,665,126.18</b>	<b>34,517,655.60</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>1,800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>24,665,126.18</b>	<b>32,717,655.60</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,369,126.18	32,717,655.60
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,296,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>28,239,450.00</b>	<b>36,816,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>28,239,450.00</b>	<b>36,816,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,239,450.00</b>	<b>36,816,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>28,239,450.00</b>	<b>36,816,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,239,450.00	36,816,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-28,239,450.00</b>	<b>-36,816,000.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>1,836,065,647.36</b>	<b>200,041,802.26</b>	<b>-317,966,147.83</b>	<b>1,718,141,301.79</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,836,065,647.36</b>	<b>200,041,802.26</b>	<b>-317,966,147.83</b>	<b>1,718,141,301.79</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн			<b>-231,702,279.57</b>	<b>-231,702,279.57</b>
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,836,065,647.36</b>	<b>200,041,802.26</b>	<b>-549,668,427.40</b>	<b>1,486,439,022.22</b>
D01	<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>1,836,065,647.36</b>	<b>200,041,802.26</b>	<b>-549,668,427.40</b>	<b>1,486,439,022.22</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,836,065,647.36</b>	<b>200,041,802.26</b>	<b>-549,668,427.40</b>	<b>1,486,439,022.22</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00		<b>1,278,517,288.52</b>	<b>1,278,517,288.52</b>
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,836,065,647.36</b>	<b>200,041,802.26</b>	<b>728,848,861.12</b>	<b>2,764,956,310.74</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,254,431,700.00</b>	<b>1,220,384,044.40</b>	<b>34,047,655.60</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,254,431,700.00</b>	<b>1,220,384,044.40</b>	<b>34,047,655.60</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,252,631,700.00</b>	<b>1,218,584,044.40</b>	<b>34,047,655.60</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>897,362,000.00</b>	<b>875,122,587.96</b>	<b>22,239,412.04</b>
210101	Үндсэн цалин	500,935,600.00	519,787,932.06	-18,852,332.06
210102	Нэмэгдэл	253,482,400.00	215,284,333.90	38,198,066.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,344,000.00	73,450,124.00	-15,106,124.00
210104	Урамшуулал	84,600,000.00	66,600,198.00	17,999,802.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>115,757,700.00</b>	<b>110,897,194.44</b>	<b>4,860,505.56</b>
210201	Тэтгэврийн даатгал	85,427,300.00	76,894,989.15	8,532,310.85
210202	Тэтгэмжийн даатгал	7,582,600.00	9,002,144.26	-1,419,544.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,066,100.00	6,736,507.64	-670,407.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,516,500.00	1,835,903.51	-319,403.51
210205	Эрүүл мэндийн даатгал	15,165,200.00	16,427,649.88	-1,262,449.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,215,500.00</b>	<b>42,761,076.00</b>	<b>2,454,424.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,781,300.00	19,794,515.00	986,785.00
210302	Түлш, халаалт	22,765,900.00	22,470,781.00	295,119.00
210303	Цэвэр, бохир ус	1,668,300.00	495,780.00	1,172,520.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>86,600,200.00</b>	<b>86,175,560.00</b>	<b>424,640.00</b>
210401	Бичиг хэрэг	3,241,300.00	3,241,300.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	32,493,300.00	32,473,450.00	19,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,383,300.00	2,353,750.00	29,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	238,300.00	73,060.00	165,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,244,000.00	48,034,000.00	210,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>8,300,000.00</b>	<b>8,241,750.00</b>	<b>58,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,300,000.00	8,241,750.00	58,250.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>83,893,300.00</b>	<b>80,982,480.00</b>	<b>2,910,820.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,311,300.00	37,320,430.00	1,990,870.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,432,000.00	12,617,400.00	814,600.00
210604	Урсгал засвар	31,150,000.00	31,044,650.00	105,350.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,800,000.00</b>	<b>4,790,100.00</b>	<b>9,900.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4,800,000.00	4,790,100.00	9,900.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,703,000.00</b>	<b>9,613,296.00</b>	<b>1,089,704.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,800,000.00	4,165,180.00	634,820.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	726,000.00	720,000.00	6,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,453,637.00	46,363.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	333,279.00	66,721.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	145,000.00	110,000.00	35,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	182,000.00	50,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	1,950,000.00	1,781,200.00	168,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,800,000.00</b>	<b>1,800,000.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,800,000.00</b>	<b>1,800,000.00</b>	<b>0.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,800,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,254,431,700.00</b>	<b>1,220,384,044.40</b>	<b>34,047,655.60</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,253,031,700.00</b>	<b>1,220,314,044.40</b>	<b>32,717,655.60</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,253,031,700.00	1,220,314,044.40	32,717,655.60
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,400,000.00</b>	<b>70,000.00</b>	<b>1,330,000.00</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,400,000.00	70,000.00	1,330,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>62.00</b>	<b>62.00</b>	<b>0.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	31.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	21.00	3.00
620004	Гэрээт ажилтан	9.00	9.00	0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймаг дахь Гаалийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Гаалийн Ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Увс аймаг дахь Гаалийн газар нь Гаалийн ерөнхий газрын дарга-Төсвийн төвлөрүүлэн захирагчтай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 46 багц ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгаж газрын тасаг, нэгж бүрээр дэд төлөвлөгөөг баталж, холбогдох албан тушаалтнуудыг өдөр тутмын мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Гаалийн шинэчлэл"-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 27.2 тэрбум төгрөгийн нэн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр "Боршоо" боомтыг олон улсын жишигт нийцүүлэн өргөтгөн шинэчлэх төслийн бүтээн байгуулалтын ажил 2020 оноос хэрэгжиж, 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр улсын комисс ажиллан барилга, байгууламжийг хэсэгчлэн хүлээн авсан байна. Үүнд: Дулаан агуулах, лабораторийн байр, албан хаагчдын амьдрах орон сууцны байрыг хэсэгчлэн, байгууламжаас дулааны зуух, халуун хүйтэн цэвэр усны шугам, аспалтан зам, цэвэрлэх байгууламж болон усан санг хүлээн авч ашиглаж байгаа бөгөөд бүрэн хүлээн авсны дараа хөрөнгө бүртгэлд тусгахаар байна.

Гаалийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн №Б/08 тушаалаар Мэргэжлийн хяналтын хорио цээрийн алба нэгдсэнтэй холбоотой төрийн тусгай 8 албан хаагч, төрийн үйлчилгээний 1 албан хаагч нийт 9 албан хаагчаар бүтэц орон тоо нэмэгдэн ажиллаж байгаа бөгөөд Боршоо хилийн боомт шинэчлэгдэж боомтоор өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4.8 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын автомашины тоо 6.7 дахин нэмэгдэх ачааллыг даах хүчин чадалтай болох тул Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн №А/63 тушаалаар бүтэц, орон тоо шинэчлэгдэж ТТ-44, ТҮ-24, улирлын гэрээт ажилтан 9, нийт 77 албан хаагчийн бүтэц орон тоо батлагдсан.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,278,517.3 мянган төгрөгөөр буюу 86 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	139.1	139.1
Бараа материал	41,611.5	81,765.7	40,154.2
Үндсэн хөрөнгө	1,444,827.5	2,683,051.6	1,238,224.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,486,439.0</b>	<b>2,764,956.3</b>	<b>1,278,517.3</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,486,439.0	2,764,956.3	1,278,517.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,486,439.0</b>	<b>2,764,956.3</b>	<b>1,278,517.3</b>

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 139.1 мянган төгрөг болж өссөн нь ажиллагсадтай холбоотой хувь хүмүүсээс авах авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 81,765.7 мянган төгрөг болж 40,154.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал, аж ахуйн материал, эм боох материалын худалдан авалт, зарцуулалтаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгийн данс нь 2,683,051.6 мянган төгрөг болж 1,238,224.1 мянган төгрөгөөр өссөн нь балансаас баланст шилжүүлэн авсан 1,872,483.1 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 36,816.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжөөр нэмэгдэж, тайлант онд 256,084.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,764,956.3 мянган төгрөг болж 1,278,517.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тайлант онд авлага, өр төлбөр үүсээгүй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,095,215.3 мянга, үйл ажиллагааны орлогоос 1,400.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,096,615.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,252,598.6 мянган төгрөгөөр бууруулж 844,016.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Боршоо хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлтэй холбоотой бүтэц орон тоо нэмэгдсэнээс шалтгаалан цалингийн зардал, ашиглалтын зардал, тоног төхөөрөмж шинээр худалдан авах зардлыг тооцсоныг хассан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотголоор 410,383.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,254,431.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1.253,031.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,220,384.0 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын төсвийг 32,307.7 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна. Үүнд: Цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал голлох нөлөө үзүүлсэн байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205-Татвар хураалт, орлого бүрдүүлэлт 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,249,731.7	1,217,424.0	32,307.7	97.4%
2	80103-Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	1,500.0	1,090.0	410.0	72.7%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	1,800.0	1,800.0	0.0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд Увс аймаг дахь Гаалийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,443.2 сая төгрөгийн 0.5 хувь буюу 7.2 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 5.8 сая төгрөгөөр тогтоолоо.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 147, хугацаа хоцроосон 2 мэдээллийг байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт**

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг Увс аймаг дахь Гаалийн газар нь тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Увс аймаг дахь Гаалийн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж байхгүй.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /Б.ОДГЭРЭЛ/

2023 оны 02 сарын 14-ний өдөр